

Мөн үнсийг ашиглаж блок үйлдвэрлэх технологийг ШУА-ийн эрдэмтдээр хийлгэж 11, 12 дугаар хорооны айлуудад хэрэгжүүлж байна.

ИТХ-аас дүүргийн зам тээврийн осол аваарын судалгааг хийлгэж, Замын цагдаагийн газартай хамтран ажиллаж байна.

Тус дүүргийн ИТХ-ын ажилтай Монгол Улсын 21 аймгийн ИТХ-ын Төлөөлөгчид, 200 гаруй сумын ИТХ-ын дарга болон Төлөөлөгчид танилцаж туршлага судлаад байна.

Тус дүүргийн ИТХ нь төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтын хуулийг батлахын өмнө УИХ-ын төсвийн байнгын хороо, хууль зүйн байнгын хороотой хамтран онол практикийн бага хурлыг зохион байгуулж бүх шатны ИТХ-ын нарийн бичгийн дарга нарыг орон тооны болгох асуудалд санал дэвшүүлж байсан.

Мөн Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчлэсэн найруулгыг батлахын өмнө УИХ-ын төрийн байгуулалтын байнгын хороотой хамтран "Нутгийн өөрийн удирдлагын байгууллагын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь" сэдэвт онол практикийн бага хурлыг зохион байгууллаа.

ИТХ нь тус дүүргийн бодлогын чанартай асуудлуудыг боловсруулан гаргаж бүх талын судалгааг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хийлгэж чадсан нь онцлог юм.

Сайн судалгаатай ажлыг хэрэгжүүлэхэд ч хялбар байдаг нь тус дүүргийн ЗДТГ-ын үйл ажиллагаанаас харагдаж байдаг.

Бодлого тодорхойлохдоо зөв болон хэрэгжих үндэслэлтэй хэрэгжсэн зүйл нь урт удаан наслаж байх нь гол зорилт болж байдаг.

1.3. ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НУТАГ ДАХЬ ТҮҮХ СОЁЛ, БАРИЛГА АРХИТЕКТУРЫН ЗАРИМ ӨВӨӨС

Хөврөн үргэлжилж, хөрвөн эргэлдэх хүмүүний орчлонгийн амьдрал хуурмаг бөгөөд сонихон. Цаг хугацааны бугалган дор хүмүүс бид үүсгэн бүтээх хийгээд орхин гээхийн аль алиныг солбилцуулан, хөгжин урагшилж аж төрсөөр ирсэн амой. Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэр дээр ч үе үеийн хүн зон зуун зууныг өртөөлөн аж төрсөөр, өөрсдийн түүхэн ул мөрөө үлдээсээр иржээ.

Их Хүрээ үндсэндээ 1778 онд Сэлбэ голын хөндийд бууснаар сууриншиж эхэлсэн бөгөөд түүнээс хойш 1830-аад оны сүүлчээр ганц удаа хол бус нүүдэл хийгээд 1855 онд урьд байсан Сэлбэ голынхоо хөндийд төвлөн байршжээ.

Чухам энэ л голомт нутаг бол одоогийн Улаанбаатар хотын төвийн хэсэг ба түүний дотор Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрийн нэгээхэн хэсэг хамрагдана. Тийм ч учраас Их Хүрээ, Улаанбаатар нийслэлийн маань гал голомт бадамлан ассан унаган нутагт одоогийн энэ л дүүргийн нутаг дэвсгэрийн нэгээхэн хэсэг багтаж байсан гэж хэлж болно. Тэр цагаас хойш энэ дэвсгэр нутаг хүн ардын хөл үл тасрах, хөгжүүн хөдөлгөөнтэй газар байсаар иржээ. Үүнийг төр шашин, худалдаа эдийн засаг, ахуй амьдралын замнал түүхийн олон арван баримтаар дэлгэн өгүүлж болох юм. Энд бид тэр болгоныг тоочин өгүүлэх нь илүүц буй за хэмээн санана. Гэвч өчигдөргүй өнөөдөр, өнөөдөргүй маргааш гэж байдаггүй болохоор дүүргийн дэвсгэр нутагт хамаарах урьд цагийн улбаа түүхийг, түүний ерөнхий дүр төлөвийг илтгэх, онцлог гэсэн цөөн зарим жишээ баримтанд тулгуурлан цухас боловч хөндөн гаргах нь зүй ёсны хэрэг хэмээн үзлээ.

1778 онд анх Их Хүрээ Хүй мандалаас Сэлбэд нүүдэллэн ирж, Хан уулын ар, Хатан Туулын хөвөө, Сэрүүн Сэлбийн дэнж, Хүн чулууны хонхорт төвлөн буусан тэр үеэс одоогийн Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт хүн ард, хүрээ дацангийн гэр, байр баригдаж, суурин амьдралын дүр төрх орж эхэлсэн аж.

XX зууны эхэн болоход эдүгээгийн Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн төвийн нутгийг хамарсан Богдын Хүрээ буюу Зүүн Хүрээ энд нэгэнт төлөвшин тогтож, өргөжин тэлсээр байлаа. Тэр үед Зүүн Хүрээ 30 аймагтай байсан нь арван тав, арван таваараа хойноосоо урагш, 2 жигүүр болон цувран байрладаг байжээ. Тэдний баруун жигүүрийн хамгийн хойд талд Сангай аймаг, хамгийн урд талд Шүтээний аймаг орших ба эдгээр 15 аймгийн газрын баруун талын хэсэг нь үндсэндээ Чингэлтэй дүүргийн нутагтай залгалдан оршиж байсны дотор Дондилин, Жадар, Тойслун, Дүйнхор, Сэцэн тойн, Амдуу нар, Дашдандарлин, Махамаяа, Жас хэмээх 9 аймгийн дуган сүм, лам нарын гэр, хашаа энэ дүүргийн нутагт хамаарах газар байв. XIX-XX зууны зааг үеийн баримт мэдээнээс харахад Зүүн Хүрээний Цогчин дуганаас баруун урагш, одоогийн 5-р сургуулийн зүүн өмнө Зурхайн дацан, түүний урд талд "Дуу үл

тасрах" хурлын сүм, Түвд модон барын хэвлэлийн газар байрлаж байжээ. Энэ мэт сүм хурлын газар Чингэлтэй дүүргийн одоогийн дэвсгэр нутагт цөөнгүй байсан билээ. Түүний нэг нь Шадублингийн хийд юм.

XIV жарны шар морь жил буюу 1858 онд Богд Жавзундамба хутагт Чингэлтэй уулын "Улаан бумбат" гэдэг газарт билгэ зохист хэмээн Шадублин хийдийг барьсан нь Дулба ёсны санаавар сахилыг чанд сахьдаг гайхамшигт өвөрмөц дэгтэй сүм байсан гэдэг ба энэ үеэс уг амыг "Шадивлингийн ам" хэмээдэг болсон байна. Уг хийдийн тухай хууч мэдээгээр бол лам нар нь нэг жимээр цувж явдаг, үдэш оройн цагаар эмс охид, энгийн ард иргэд, гадны хүмүүсийг хүрээ гороондоо хонуулдаггүй, аглаг номын орон байжээ. Тус хийд нь Зүүн Хүрээнд шууд захирагдах ба лам нар даяан хийж, ном бясалгах зорилгоор зориуд зорин очиж, хэсэг хугацаагаар суудаг, даяанч лам нарын хийд байсны дээр Богдын зарлигаар Монголын нууц тагнуулын ажилтнуудыг энд сэм бэлтгэдэг байсан гэдэг ч мэдээ байдаг. Тэрчлэн Шадублин хийдэд өргөл мөргөл үйлдсэн хүмүүст тарган Гонгор бурхныг шавраар үйлдэж өгдөг байсан ба бурхан бүтээдэг, уг нарийн нандин шавраа Чингэлтэй уулаасаа авдаг байсан мэдээ бас бий. Өдгөө ч Чингэлтэй уулын Заан хошууны хавирга биеэс улаан, хойшлоод хонгор шаргал шороо гардагийг хүн ард ашигласаар байгаа нь үүнтэй учир шижим холбоотой байж болох юм.

Дүүргийн дэвсгэр нутагт улс төрийн томоохон зүтгэлтнүүд, нам хувьсгал, хөгжил дэвшлийн түүхтэй холбоотой газар орон, байр байшин, гудамж талбай олон буй. Түүхэн газар зүй судлаач, эрдэмтэн О.Пүрэвийн тодорхойлсноор одоогийн 10 жилийн 5-р дунд сургуулийн тэр хавь, орон сууцны 1-р байрны орчимд буюу хуучин Сэцэн тойны аймгийн өргөн чөлөөний зүүнээсээ тав дахь хашаанд 1921 оны хувьсгалын анхны долоогийн нэг, ардын түр засгийн газрын анхны ерөнхий сайд, сүүлд Богдын шадар сайдад ч дэвшиж явсан Чагдаржавынх болон Дүйнхорын аймгийн лам, шадар сайд да лам Пунцагдорж нарын зэрэг Монголын төр, нийгмийн нэрт зүтгэлтнүүд аж төрдөг байжээ. Д.Сүхбаатар Хужирбулангаас ирээд хадам аав Өвгөнхүүгийн төхөөрөн өгсөн гэрт гэргий Янжмаагийн хамт амьдран сууж байсан газар нь одоогийн Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт нийслэлийн 23-р дунд сургуулийн баруун хойд талд бий. Мөн түүнчлэн Д.Сүхбаатарын

түр хөлсний ажил хийж байсан Орос пүүсний байшин нь одоогийн "Туул" зоогийн газрын баруун хойт талд буй дан модон байшин гэдэг. Үндэсний хувьсгалын ялалтын дараа Д.Сүхбаатарт хуучин Сэцэн ханы хашаа байшинг олгож, тэнд таван ханатай, өндөр шалтай гэр бариулан нас нөгцөх хүртлээ амьдран сууж байсан нь одоогийн Чингэлтэй дүүргийн дэвсгэр нутагт харъяалагдах газарт байрлаж байжээ.

Хувьсгалчдын дурсамж тэмдэглэлээс үзэхэд Зөвлөлийн засагт Орос улсад тусламжийн хэргээр зарагдсан С.Данзан, Х.Чойбалсан нар 1920 оны зуны дунд сарын 13-ны өдрийн нар таших үеэр Нийслэл Хүрээнээс мордохдоо тус дүүргийн нутаг-Баруун дамнуурчны 2-р гудамжаар явж, Гандангийн зүүн хойд тал Тасганы энгэрээр замнан их замдаа шуудран нийлж, цааш Мааньтын давааг давж одсон байдаг. Эдгээр нь өдгөө цөм Чингэлтэй дүүргийн нутаг болно. Мөн түүнчлэн төдий л удалгүй намын даалгавраар тэдний араас одсон Сүхбаатар, Лосол, Догсом нар Хүрээнээс сэмхэнээр гарч, Чингэлтэй уулын аманд бүхий журмын нөхөр Дугаржавын гэрт очиж (нийлэлдэн) цааш Сэлбэ голыг өгсөн хойд этгээдийн Гүнтийн зэрэг өндөр бэрх уул даваан дундуур зам буруулан явахдаа хоноглосон Шанага, Манхтайн даваа, Хүйтэн зэрэг нь мөн л эдүгээгийн Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт оршино.

Одоо бидний "Тасганы энгэр", "Тасганы овоо" хэмээн нэрлэдэг хошуу толгодыг урьд "Зөөлөн хошуу" гэдэг байж. Хүрээнийхэн түүнийг Зааны хошуу шинжтэй хэмээн бэлэгшээдэг. Гандан хийгээд Зүүн Хүрээний лам нар хоорондоо ном хаялцахдаа заавал энд цуглан цэц сорилддог байсан ба тэдний ийнхүү ном эрдмийн хүчээр мэтгэлцэн тэмцэлдэхийг тэр цагт "Тасга хаялцах" хэмээн нэрлэж агсан ажгуу. Чухам үүнээс үүдэн хожим "Зөөлөн хошуу"-г тийн "Тасганы" хэмээн нэрийдэх болсон хэмээмэй.

Түүх шаштирт тэмдэглэснээр энэ л хошуугаар дамжин Монголын дэвшилт ардчилсан хүчний зарим удирдагчид 1920 оны 7-р сард үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын их үйл хэргийг гүйцэлдүүлэхээр одож байсан төдийгүй 1921 оны 7-р сарын 6-ны өдөр Монгол Ардын Журамт цэрэг Зөвлөлтийн улаан армийн зарим анги нэгтгэлийн хамт Нийслэл Хүрээг чөлөөлөхөөр орж ирэхдээ мөн л үүгээр дайран ирсэн ховор түүхт газар билээ.

Тэрчлэн өнгөрсөн зууны эхэн үед одоогийн Чингэлтэй дүүрэгт

харьяалагдаж буй Их Хүрээний тэрхүү дэвсгэр нутагт Монголын түүхэнд нэр алдаршин үлдсэн “Бадарчны дов”, “Их зээл”, “Янчааны гудамж”, “Махан дов”, “Усны гудамж”, “Баруун дамжуурчин”, “9 гудамж” зэрэг алдартай гудамж зээл оршиж байв. Тэдгээрийн заримаас цухас өгүүлбэл: 1836 оны үед Их Хүрээ баруун тийш шилжин төвлөхөд Маймаа хотоос зай алслан холдсоныг дашрамдуулан ашиглаж Богдтой ойр дотно зарим хятад пүүс түүний тусгай зөвшөөрлөөр Гандангийн дэнжийн хүр доор бууж, дэлгүүр хоршоогоо нээн суух болжээ. Удалгүй бусад пүүсүүд ч тэдний араас дагалдан тэнд нүүн ирэх болсноор арилжаа наймаа өргөжин, хүн амьтан хөлхөлдсөн худалдааны гудамж үүссэн байна. Тийнхүү XIX зууны тэргүүн хагасын сүүл үед Хүрээний баруун талд 9 гудамж бүхий “Баруун дамнуурчны” гэж нэрлэгдсэн нэгэн өвөрмөц хэсэг буй болсон аж.

Баруун дамнуурчин нь урдуураа Түшээт хан аймгийн Сэцэн вангийн хороо, Түшээт ханы суурин жасаа, Сахалын хэмээх Хятад пүүстэй, зүүн талаараа Зүүн хүрээний эргэл мөргөлийн замтай, хойгуураа Ногоон нуурын урд хөвөө, баруун, баруун хойд талаараа Зөөлөн хошуу (Тасган)-ны зүүн бэлээр савласан нутгийг хамардаг, гудамжууд нь баруунаас зүүн тийш чиглэн сунаж тогтсон, тэднийг дундуур нь хөндлөн огтолсон ганц урт гудамжтай байжээ.

Тэнд Шаньси муж Бээжин хотын томоохон пүүсүүдийн салбар болох Жэнь-Хойн (Баянмөнхийн) Дунь Фу-Югийн (Баярын), Лунь Чань Юйн (Бээжин Батын), Лунь Синий (Хишигтийн), Се Хогуны (Бээжин Содномдаржаагийн) гэх зэрэг 35 том пүүс, олон тооны жижиг, дунд дэлгүүр мухлагууд байв. Судлаачдын бүтээлд дурдсанаар бол баруун дамнуурчны 9 гудамжинд нийдтээ үйлдвэр, үйлчилгэний 217 жижиг газар ажиллаж байжээ.

Баруун дамнуурчны өмнөхөн талд Орос худалдаачид иргэд өөрсдийн хашаа хороо, дэлгүүр агуулахаа барьж суурьшин суудаг байлаа. Тухайлбал, Хүнсний Шар дэлгүүр буй газарт “Черты” хэмээх Копытовын их пүүсийн нэгэн байр, “Урт цагаан”-ы зүүн үзүүр хавьд Ягудины пүүсийн дэлгүүр, Барилгын зургийн институт байгаа тэнд Каковин, Басовын хувь нийлүүлсэн их пүүсийн төв байр, түүнээс урагш Боловсролын хүрээлэн хавьцаа Богдановын пүүс, Урмачеев, Серебряковын хувь нийлүүлсэн татар пүүсийн дэлгүүр (одоогийн ховор номын дэлгүүр) тус тус байрлаж байжээ.

Ардын засгийн эхэн үед тэдгээрийн зарим байранд Зөвлөлтийн худалдааны “Сторминг” пүүс, “Центрсоюз” худалдааны төв контор байрлаж байсан аж.

Чингэлтэй дүүргийн баруун өмнө зах буюу Баруун дөрвөн замын бэлчир хавиас хуучин их Хүрээний баруун өмнөд хороонд багтаж байсан “Бадарны дов” эхэлдэг байжээ. Энэ дов дээр Дотоод явдлын яамны ажилтнуудад зориулсан тусгай халуун усны газар ажиллаж байсан ба түүнийг хожим Хими цэвэрлэгээ угаалгын комбинат болгожээ. Бадарчны довын хойт хэсэгт баруун Сэлбэ голын нэгэн гүүр байсныг Зодоч нарын гүүр гэдэг байсан ба энэ гүүрний баруун талд Зод лүүжингийн хурлын дуган, түүний орчимд Гандангийн дэнжийн зүүн ёроол хүртэл олон айл бүхий Буриадын хороо оршиж байв. Тус хорооны дэвсгэр нутагт Герман улсын “Востбанк” хэмээх худалдааны пүүсийн нэгэн салбар байрладаг байсан ба хожим түүний суурин дээр Мебелийн фабрик байгуулагдсан нь өдгөө ч ажилласаар буй.

Мөн Туул зоогийн газрын хавьд бадарчны “Шургадаг суврага” хэмээх нэгэн суврага байсан нь бадарчид гэр орондоо буцаж ирэхдээ түүгээр шурган элдэв муу зүйлээ ариутгах зан үйлийн зориулттай байсан гэдэг.

Мөн түүнээс гадна мал нядлахын өмнө шургуулж сүнсийг нь зайлуулах учиртай бас нэгэн суврага байсан аж. Буриадын хорооны зүүн талд залгаад баруун Сэлбэ голын зүүн тохойд Түвэдийн хороо гэж байжээ. Тэр үед Түшээт ханы хорооны өмнүүрэх гудамжийг их зээлийн буюу шинэ захын гудамж гэж нэрлэдэг байжээ.

Харин хожим хотын захыг одоогийн Зорчигч тээврийн товчооны зүүн талд шилжүүлснээс хойш Их зээлийг хуучин зах хэмээн нэрлэдэг болсон байна. Их зээлийн баруун талд төмрийн дархны газрууд нэг хэсэг төвлөрөн байснаас үүдэн баруун Сэлбийн нэгэн гүүрийг бас Төмөрчний гүүр гэдэг байжээ. Энэ нь одоогийн хүнсний захын Шар дэлгүүрийн зүүн өмнөд талд оршдог байв.

Чингэлтэй дүүргийн дэвгэр нутгийн баруун өмнө хэсэгт буюу Их зээлийн урдхан талд Сулейманов гэгч татар худалдаачны хувийн клуб, түүнээс зүүхэнтэй Хятадын халуун усны газар, одоогийн Туул зоогийн газрын баруун өмнөд этгээдэд Англи улсын “Бедерман” хэмээх их пүүсийн нэгэн дэлгүүр, хуучин Усны гудамжны баруун эхэнд Америк улсын Андерсенмярын пүүсний

салбар болох есөн хуруут Ланчансан хэмээхийн их пүүс, түүнээс урдхан өмнө өгүүлсэн Германы Востбанкийн Монгол дахь төв захиргаа, одоогийн Шар дэлгүүрийн ойролцоо 1919 оноос Швед улсын харъяат их эмч Герда Оллен, Грета Нильсон нарын санаачлан байгуулсан хүн эмнэлэгийн газар ажиллаж, тэнд 1921 оноос Швед бага эмч Гертруд Фольк ажилладаг, тэрчлэн 1923 оноос мөн Шведийн иргэн Дагни Хансен, Сигне Фольке, Магнус Берлунд нарын зэрэг багштай бага сургууль нээгдэн хичээллэж байсныг, төдөлгүй тэднийг Монголоос хөөн явуулсан зэргийг эрдэмтэн О.Пүрэв өөрийн бүтээлд сурвалжлан тэмдэглэсэн байдаг.

Баруун Сэлбэ голын урд дов дээр буюу одоогийн "Барилгачдын талбай" хавьд мах худалдаалдаг зах байсан учир олны дунд тэр нь ---"Махан дов" гэгддэг байв. Харин хожим хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу 1960-аад оны эхээр төв дундаа цэцгийн мандал, урд хойд талдаа авто зогсоол бүхий 5000м² шинэ талбай барьж байгуулан үүнийг 1970 оноос "Барилгачдын талбай" гэж албан ёсоор нэрлэжээ. Энэ талбайн орчимд урьд нь, 1927-1928 оны үеэс "Спартак" хэмээх зочид буудлын 2 давхар дүнзэн барилга, 1930-аад онд гар үйлдвэрийн анхны клуб, Улаан загалмайн халуун ус, Төв аптек зэрэг соёл үйлчилгээний газрууд байсан ба 1940-1950-иад онд нийслэл хотын шинэчлэн байгуулалтаар энэ орчимд одоо буй шинэ шинэ барилгуудыг барьсан байна.

Өдгөө дүрслэх урлагийн музей байгаа 2 давхар байшин нь өөрийн өвөрмөц түүхтэй ховорхон дурсгалт барилгуудын нэг юм. Урьд нэтэнд 1915 онд Орос-Монголын худалдаа, үйлдвэрийн банк, дараа нь Хятад гамингийн банк, 1921.7.6-нд АЖЦ, Улаан армийн ангиудын түрүүч нийслэл хүрээнд орж ирэхэд цэргүүдийн нэлээд олонхи нь тэнд буудаллаж байсан ба улмаар Мал тариалангийн яам, Улсын их дэлгүүр зэрэг байгууллагууд байрлаж байжээ. Түүнээс зүүхэнтэй анхны Хүрээний Орос бага сургууль, хойд талд нь анхны Орос эмийн сан зэрэг олон газар байрлаж байсан бөгөөд эмийн сангийн барилга эдүгээ ч буй билээ.

Одоогийн Монгол банк, МОНЦАМЭ буй газарт "Хүрээний Оросын хороо" гэгдэх Оросын харъяат олон айлууд байсан гэдэг. Энэ хавьд Австри улсын иргэн В.П.Генрих гэгч нэгэн Орос офицертэй хамтран "Лимонад"-ны (хийжүүлсэн ундааны) үйлдвэр ажиллуулж байжээ.

МҮЭ-үүдийн холбооны байр орчимд Богд хаант улсын баруун гаалийн хороо байрлаж байсан аж. Орос хорооллын хойхонтой Мөргөлийн хүрд эргэх чөлөөнд 1935 онд ДЯЯ-ны 2 давхар барилгыг барьж ашиглалтанд оруулснаас гадна урд талын зам чөлөөг 1936 оноос эхлэн шороо чулуу дагтаршуулан засаж, 1939 оноос "Чойбалсангийн чөлөө" гэж нэрлэсэн байна. 1949 онд энэ хавийн зам талбайг цардан, зүлэг мод тарьж цэцэрлэгжүүлэн, хайс хашлага хийх зэргээр 150х35м газрыг тожижуулсан нь, "Чойбалсангийн талбайн цэцэрлэг" гэж нэрлэгдэж байв. Хожим энд Сибирийн алдарт партизан, 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалд оролцож, Монголчуудын дунд Төмөрбаатар жанжин хэмээн алдаршсан П.Е.Шетинкиний хөшөөг босгосон билээ.

Сүхбаатарын талбай, Засгийн газрын ордны баруун талаас баруун тийш Урт цагаан хүрэх замыг урьд нь "Архангайн гудамж" гэж байсныг тэр үед "Лениний гудамж" болгоод хожим 1960-аад оноос "Октябрийн гудамж", одоо "Худалдааны гудамж" гэх болсон байна. 1918-1919 оны үед Нийслэл Хүрээнд үүссэн хувьсгалт нууц бүлгийн нэг нь зүүн Хүрээнд байсан тул Монголын түүхэнд "Зүүн Хүрээний" гэгдэн тэмдэглэгдэж ирсэн билээ. Тухайн үед энэхүү бүлгийнхэнтэй хэлхээ холбоотой ажиллаж байсан Оросын хувьсгалч Я.В.Гембержевский тэр цагт баруун дамнуурчны Орос "Чоорт" (Черт)-ын пүүсны 1907 онд баригдсан 2 давхар дүнзэн байшингийн дээд тасалгаанд суудаг, нягтлан бодохын ажил эрхэлдэг байжээ.

Тэрчлэн Оросын хувьсгалт байгууллагын даргаар сонгогдон ажиллаж байсан Б.Н.Чайванов мөн тэр байшинд суудаг байсан мэдээ буй. Мөн түүнчлэн 1918 онд уг байшингийн урдах талбайд (одоогийн Ялалтын талбай орчимд) Оросын харъяат нар цуглаан хийж, хуучин засаг төрд захирагдахгүйгээ илэрхийлж байсан гэдэг.

1920-иад оны сүүлчээр тус улсад шинжлэх ухаан эмнэлэгийн ажилтнуудыг бэлтгэх зорлиготой анхны Сувилагчийн сургууль нээгдэн энд хичээллэж, бидний сайн мэдэх доктор П.Н.Шастин хичээл зааж байлаа. Хожим манай төр засгаас баруун дамнуурчны эхэн дэх энэхүү 2 давхар модон байшинг "Хувьсгалт нууц бүлгийн байр" хэмээн үзэж тусгай дурсгалын самбар хадан улсын хамгаалалтанд авсан юм.

Энэ мэт Нийслэл хотын төдийгүй улс орны маань түүхтэй салшгүй холбоотой түүх соёлын дурсгалт байгууламж, барилга байшин тус дүүргийн нутаг дэвсгэр дээр цөөнгүй бий. Тэдгээрийн заримаас энд товч танилцуулья.

Гэсэр сүм: Одоогийн Чингэлтэй дүүргийн нутаг, хуучин баруун дамнуурчны гудамжны эхэн дэх Тасганы овооны өвөрт байрлах сүм хийдийн нэгэн цогц байгууламжийг “Гэсэр сүм” хэмээдэг билээ. Энэ сүмийг 1919-1920 оны үед Хятадын Хөхийн шашны шүтлэгтэн Гүвэ овогт Захар гэгч хүн Нийслэл Хүрээн дэх Хятадын баян чинээлэг пүүсийн эзэд, хятад иргэдийн хандив мөнгөөр анх байгуулжээ. Гуанди шүтээний сүм буюу “Гэсэр сүм” гэдэг нь угтаа Хятадын нэгэн том цэргийн жанжин болох Гуан-юйн өргөмж нэрээс үүдэлтэй бөгөөд Манж Чин гүрэн байгуулагдах үед Гуан-Юй жанжны сүнс залран ирж түүний сүр ивээлийн хүчээр дайснаа даран сөнөөж, их гүрнийг байгуулсан хэмээн түүнийг ихэд өргөмжлөн дээдлэх болж, олон сүм хийд байгуулагдан дүрийг нь залан шүтэх болсон ажээ. Үүний нэгэн илрэл тусгал нь манай Гэсэр сүм болно. Манж Хятадын байгуулсан дайны тэнгэр Гуанди сүмийг Монгол, Түвэдийн ард түмэн өөрсдийн дунд өргөн тархсан домогт туульсын алдарт баатар Гэсэртэй нэр холбон адилтгаж үзсэнээс ийнхүү нэрлэгдэх болсон бололтой. Гэсэр сүмийн байгууламж нь сүмийн гол хаалганы баруун талд барьсан хятад маягийн жижиг дэрэвгэр оройтой, жин хэнгэрэг, хонх бүхий хоёр сүүдрэвч, Гуанди-мио буюу Гэсэрийн сүм, гол сүмийн өмнө талд орших өргөл мөргөлчдийн хоёр байр, хамгийн өмнө талд орших Хөлгийн сүм хэмээх жижиг сүм, гол сүмийн ард орших Хөхийн шашны сургуулийн хоёр байшин, Гүвэ овогтын сууцны байшин, сүмийн хэрмэн хашаа зэргээс бүрдэнэ.

Гэсэр сүмийн гол шүтээн нь Гуанди болон түүний туслах баатруудын дүр бүхий баримал шуумал болох ба тэнд мөн Тансан ламын үлгэрээр сэдэвлэсэн намтарчилсан дүрс зураг, баримал байхаас гадна сүмийг барих үед мөнгө өргөсөн хүмүүсийн нэрсийг жагсаан бичсэн чулуун самбар байсан бөгөөд сүмд Хятад лам нар сууж ном хурдаг байжээ. Хөлгийн сүм гэдгийн баруун, зүүн тасалгаанд Гуан-ди жанжны улаан, цагаан хүлэг морины баримал байдаг, Сургуулийн хоёр байшинд Хятад хүмүүс сайн дураараа ирж суудаг байв.

1933 онд уг сүмийг улсын мэдэлд авч, түүнээс хойш янз бүрийн байгууллагууд байрлаж ирсэн ба 1966 онд Гандан хийдийн нэрт уран барималч, зураач Данзан ламтан хуучин байсан Гуандигийн Хятад баримлыг Гэсэрийн туужид түшиглэн өөрчилж, цаас шавраар морь унасан Гэсэр баатрыг баруун талд нь Цасчихэр, зүүн талд нь Рогмагуа хатан байгааг дүрсэлсэн шавар цаасан баримал бүтээжээ. Гэсэр сүм нь өөрийн өвөрмөц онцлог, хийц загвар бүхий түүх соёлын дурсгалт уран барилгын нэг юм.

Өндөр хоршоо: - Нийслэл Хүрээний худалдааны их захын зүүн хэсэгт “Махан дов”-ын хажуухантай 1918-1919 оны үед хоёр давхар тоосгон байшинг Оросын томоохон худалдаачид Гудвинцал бариулсан нь тэр үеийн том барилгын нэгэнд тооцогдож, үүнээс үүдэн “Өндөр” хэмээгдэх тодотголтой болжээ. Гамин цэргийн дэглэмийн үед уг байшинд Хятадын Чжи-Бянь-ин-хань (Хао-Бу-Я) хэмээх банк нээж цаасан мөнгө гаргаж байсан гэдэг. 1921 оны 7-р сарын 6-нд Нийслэл Хүрээг чөлөөлөхөөр орж ирсэн Монгол, Зөвлөлтийн цэргийн анги тэнд буудаллан улмаар Улаан цэргийн комендатын газар байрлаж, бас цэргийн эмээл хазаар, тоног хэрэгсэл, савхин гутал зэргийг хийх, сэлбэх засах үйлдвэр ажиллаж байв. Дараа нь аж ахуйн яам, Харилцах туслах хоршооны ерөнхий хороо байрлаж, дээд давхарт нь хивс нэхэх жижиг цех ажиллаж байжээ. 1930 онд уг байшинг өргөтгөн харилцан туслалцах хоршооны төв дэлгүүр болгосноор “Өндөр хоршоо” хэмээх алдрыг хүртэн түүгээрээ олны дунд нэршжээ. “Өндөр хоршоо” –ны зүүн хэсэгт одоогийн худалдааны сургуулийн анхны эх үүсвэр болох дансны ажилтны 6 сарын хугацаатай курсыг 42 сурагчтайгаар нээн хичээллүүлж байсан аж. 1954 онд тус дэлгүүрийн барилгын дотоод талыг өөрчлөн засварлаж, худалдааны том танхимуудтай болгон тохижуулсан байна. 1961 онд Улсын Их дэлгүүр шинэ байртай болж, тийш шилжин явахад энд **Дүрслэх Урлагийн музейг** байгуулсан нь өдгөө хүртэл үйл ажиллагаагаа явуулж байгаа билээ. 1966 оноос 300 гаруй үзмэртэйгээр анх үүд хаалгаа нээсэн тус музейн сан хөмрөгт эдүгээ эртний урлагийн дурсгал хадны зургаас эхлээд өнөө үеийг хүртлэх Монголчуудын сонгодог урлагийг бүхэлд нь харуулсан 10 мянга гаруй үзмэр хадгалагдаж байна. Урлаг судлаач, зураач, барималч, орчуулагч зэрэг нарийн мэргэжлийн ажилтнуудтай тус музейд эрдэнэсийн, танка зургийн, торгон зургийн, гадаад

урлагийн зэрэг үзмэрийн баялаг сан хөмрөг бий. Тус музейн нь эртний урлаг, Их Монгол Улсын урлаг, Өндөр гэгээн Занабазарын урлаг, ХҮИ-ХИХ зууны Танка зураг, Торгон зураг, ХҮИ-ХИХ зууны модон барын зураг, Цамын бүжиг, Уран барилгын уламжлал, Ардын урлаг гэсэн төрөлжсөн сэдвүүдээр сан хөмрөгөө нийтэд дэлгэн үзүүлж байна.

“Өндөр хоршоо”-ны хойно “Махан дов”-ын зүүн хажууд байх бас нэгэн дурсгалт газар бол “Европ эмнэлэгийн аптек” –ын байшин юм. Хувьсгалын өмнө Их Хүрээнд Оросын консулын бие хамгаалах цэргүүд болон Оросын харъяат нарт үйлчлэх Европ эмнэлэгийн амбулатори ажиллаж, түүнд нь Монголчууд ч хааяа үзүүлдэг байж. Тэрхүү амбулаторийн харьяанд 1910-аад оны үед Европ эмийн сан (аптек) байгуулсан нь тэр байв. Хувьсгалын ялалтын дараа уг байшинд Цэргийн оёдлын үйлдвэр, дараа нь Ардын засгийн цагдан сэргийлэх байрлаж байлаа. 1925 онд Эрүүлийг хамгаалахын харьяанд Европ эмнэлэгийн аптекийг тэнд байгуулж, 1930 онд уг байшингийн зүүн талд нэгэн шинэ байшин барьж тэнд шилжүүлэн байрлуулсан нь нэгэн үе 1-р аптек гэгдэж байсныг бид мэдэх билээ. Дээрх анхны аптекийн байшинд түүнээс хойш хотын аптекуудын удирдах контор олон жил байрлаж байсан юм.

Банкны байшин – Хувьсгалын ялалтын дараа үндэсний эдийн засгаа сэргээн хөгжүүлэх нь ихээхэн чухал байлаа. Тийм учраас Ардын засгийн газрын шийдвэрээр 1924 онд Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн “Монголын худалдаа аж үйлдвэрийн банк”-ыг нэгэн жижиг модон байшинд анх нээсэн нь хожмын Монгол банкны эх суурь болжээ. Банкны үйл ажиллагаа өргөжин улс орны цаашдын хөгжилд улам их үүрэг хүлээх болсонтой холбогдуулан Нийслэлийн худалдааны захын зүүн эхэнд банкны шинэ байшинг барьж 1933 онд ашиглалтанд оруулав. Уг байшинг 1938 онд өргөтгөн давхарласан хэсэгт нь Улсын банк, зүүн талын хэсэгт нь БНМАУ-ын Сангийн яам байрлах болж, одоо ч байсаар буй.

“Шар дэлгүүр” – Ардын засгийн эхний жилүүдээс эхлэн улс хоршооллын худалдааг хөгжүүлэх үндсэн дээр үндэсний худалдааг үүсгэн хөгжүүлэх явдалд ихээхэн анхаарал хандуулж ирсэн билээ. Түүний нэгэн илрэл нь Нийслэл хотын худалдааны их захад төвлөрч байсан гадаад дотоодын хувийн худалдааны газруудтай өрсөлдөж чадахуйц орчин цагийн тохилог худалдаа

хөгжүүлэх, дэлгүүр барьж байгуулах үүднээс Монголын эд хэрэглэгчдийн хоршооны хотын хэлтсээс эрхлэн баруун захын дэргэд нэгэн дэлгүүрийн байшин шинээр барьж, 1936 онд нээсэн нь хожмоо “Шар дэлгүүр” хэмээн алдаршжээ. Энэхүү байшин бол Улаанбаатар хот дахь дэлгүүрийн зориулалт бүхий анхны тохилог, тоосгон барилга байсан бөгөөд одоо хүртэл үндсэн чиглэл, зориулалтаа хадгалан ажилласаар байна.

“Алтай зочид буудлын барилга” – 1940 оны 6-р сард хуралдсан улсын ҮИИ их хурлаас зочид гийчдэд үйлчлэх буудлын газар байгуулах нь чухал болох тухай заасныг үндэслэн мөн онд 170 ор бүхий зочид буудлын барилгын зураг төслийг Москвагаас захиалан авсан байна. Гэвч уг барилгыг барих ажил дэлхийн II дайны цаашдын өрнөлтийн улмаас хойшлогдсон юм. Дайны дараа буюу 1946 онд тус зочид буудлын барилгын суурийг тавьж барьж эхэлсэн ба 1948 оны 7-р сарын 7-нд ашиглалтанд оруулжээ. Нийтдээ 19000 м³ багтаамжтай 60 гаруй өрөө тасалгаа бүхий, зүймэл царсан шалтай, доод давхартаа тохилог гуанзтай энэ барилгыг Монголчууд өөрсдийнхөө хүчээр, улсын барилга трест барьсан аж.

1961 онд өөр орчин үеийн шинэ зочид буудал барьж байгуулсан тул уг буудлын барилгыг албан байгууллагын байр болгон ашиглуулахаар шийдвэрлэжээ. 1964 оноос хойш эдүгээ хүртэл тэнд Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаа, Засаг даргын тамгын газар байрлаж ирсэн билээ.

“Элдэв-Очирын нэрэмжит кино театрын барилга” – Энэ бол Улаанбаатар хотын шинэчлэн байгуулах төлөвлөгөөгөөр барьж байгуулсан анхны томоохон гоёмсог барилгуудын нэг юм. Кино театрын энэхүү барилгын зураг төслийг 1945-1946 онд инженер Климов зохиожээ. Кино театр нь 9700 м³ багтаамжтай, 400 гаруй хүний суудалтай, доод, дээд давхартаа бүжиг, үзэсгэлэнгийн танхимтай 3 давхар барилга болно. 1947 оны 12-р сард уг кино театрыг Улсын бага хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор улс төрийн зүтгэлтэн Б.Элдэв-Очирын нэрэмжит болгожээ. 1948 оны 7-р сарын 8-наас албан ёсоор ашиглалтанд орж, нийтэд үйлчилж эхэлсэн аж. Нээлтийн цуглаан дээр Х.Чойбалсан хэлэхдээ: “Нийслэлийн чимэг болсон шинэ кино театр нь хотын хөдөлмөрчдийн хүмүүжил боловсролыг нэмэгдүүлэх, олон түмэнд хамгийн хүртээмжтэй ухуулгыг нэвтрүүлэх соёлын нэг төв болох

юм” гэжээ. Үнэхээр ч энэ театр олон арван жилийн турш хүн ард, хүүхэд залуучуудад соёл хүмүүжил түгээх их үйл хэрэгт үнэтэй хувь нэмэр оруулж ирсэн билээ. Тус театрын барилгыг 1955, 1962, 1968 онуудад Зөвлөлттийн архитектор, инженерүүдийн зураг төслөөр засварлан улам гоёмсог, тохилог болгожээ. Сүхбаатарын талбайн баруун захад байрлах 2-р давхартаа тойрон байрласан гоёмсог галарейтэй, дотор засал чимэглэлд нь үндэснийхээ угалз сэлтийг үлэмжхэн ашигласан уран барилгын өвөрмөц онцлог бүхий, “Хүүхдийн” хэмээх тодотголтой энэхүү байшинг Монгол улс зах зээлийн харилцаанд шилжсэнтэй холбоотойгоор хожим өөрчлөн засварлаж тохижуулаад “Монголын хөрөнгийн бирж”-ийг байрлуулсан нь одоо үйл ажиллагаагаа явуулсаар байна.

Төв хоршооны байр –Хуучин Дархан Чин вангийн хорооноос баруун хойш. Сайн ноён ханы хорооны зүүн хойт талаар, Түшээт хан аймгийн Дайчин бэйсийн хорооныхон суудаг байжээ. Энэ хорооны нутаг Сономын пүүсийн гудамжны эхэнд Автономитын үед барьсан хоёр давхар хөх тоосгон байшинд Америк улсын Андерсемьярын пүүсийн Монгол дахь төлөөлөгч “Ланчансан” хэмээх Ларисаны пүүсийн харьяа сүүдэр шийний газар ажиллаж, орой бүр яндангийн дуунаар кино гаргалтаа зарлаж гэрэл чийдэн гэрэлтүүлэн дуугүй кино үзүүлдэг байжээ. 1921 оны сүүлээр энд Монголын харилцан туслах хоршооны төв дэлгүүрийг байгуулсан ба хожим Өндөр хоршооны барилга ашиглалтанд орж дэлгүүр түүнд шилжсэний дараа уг байшингийн өрөө тасалгааг томсгон хаалга цонхыг өөрчлөн засаад “Ард” кино театрыг байгуулжээ. 1966 онд Ард кино театрын барилга баригдан театр шилжсэнээс хойш тэнд хүүхдийн ба баримтат киноны театр ажиллах болжээ.

Үйлдвэрлэл хоршооллын худалдаа үйлчилгээний нэгдсэн барилга -1950-иад оны эцсээр тухайн үед төр засгаас явуулсан бодлого шийдвэрийн дүнд хувийн гарт байсан худалдаа үйлчилгээний олон жижиг цэгүүд үндсэндээ үйл ажиллагаагаа зогсоож зарим хэсэг нь хамтын хэлбэрт шилжин зохион байгуулагдаж цаг үеийн шаардлагад нийцүүлэн үйл ажиллагаа явуулах хэрэгтэй болов. Тийм учраас худалдааны хуучин захын олон жижиг навтгар шавар болон модон байшин барилга, хашаа хороог буулган оронд нь Хоршооллын худалдаа үйлчилгээний нэгдсэн барилгыг архитектор Б.Дамбийнямын зохиосон зураг төслөөр 1959-1961 онд барьжээ. Үе үеийн Улаанбаатарчуудын

“Урт цагаан” хэмээн нэрлэж ирсэн уг барилга нь тухайн үедээ үндэсний архитекторын өв уламжлалыг тодорхой хэмжээгээр харгалзан орчин үеийн барилгад түүнийг бүтээлчээр хэрэглэхийг эрмэлзсэн сонирхолтой зохиомж бүхий барилга болсон гэж үздэг. Энэхүү барилга нь соёл ахуйн үйлчилгээ биеийн тамир спортын зориулалт бүхий олон арван өрөө тасалгаа танхимуудтай үйлдвэрлэл үйлчилгээ, худалдаа, соёлын томоохон төвийн нэг юм.

Монголын шуудан холбооны барилга – Ардын засгийн эхэн үеэс улс орондоо орчин үеийн харилцаа холбоог хөгжүүлэх түүнийг цаашид өргөтгөх арга хэмжээ авч байсны нэг нь 1930-аад оны эхээр Улаанбаатарт радио өргөн нэвтрүүлэг нээхтэй холбогдуулан Засгийн газрын шийдвэрээр радио холбооны барилгыг төв талбайн баруун өмнөд хэсэгт бариулж эхэлсэн явдал байлаа. 1933 онд МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгчдээс тусгай тогтоол гаргаж уг барилгын явцыг түргэтгэх арга хэмжээ авсаны үр дүнд 1934 онд түүнийг ашиглалтанд оруулжээ. Холбооны төв барилгыг 1950-иад оны сүүлчээс дахин өргөтгөх шаардлага зүй ёсоор дэвшигдэн тавигдаж, үүнийг харгалзан ЗХУ-ын тусламжтайгаар төв байрыг хуучин барилгатай залган барьж, 1960 оны 12-р сард ашиглалтанд оруулсан байна. Нийтдээ 35000 м³ багтаамжтай хагас дугуй хэлбэрийн үйлчилгээний тэнхим, олон арван тасалгаа бүхий энэ барилгад төв шуудан, хот хоорондын телефон станц, АТС, радио студи зэрэг орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон харилцаа холбооны салбар үндсэндээ төвлөрөн байрлаж, шинэчлэлт өөрчлөлт, өсөлт хөгжлийн олон он жилүүдийг туулан одоо хүртэл үйл ажиллагаа явуулсаар байна. 1970-1971 онд уг барилгын хойт хэсэгт өргөтгөл хийж тэнд олон жил Холбооны яам байрлаж байв.

1-р 40 мянгат - Чингэлтэй дүүрэг нийслэл хотын анхны орчин үеийн орон сууцны нэгдсэн хороолол баригдсан дүүрэг билээ. Үүний нэг жишээ нь

1-р 40 мянгатын орон сууцны барилгууд юм. Монгол-Зөвлөлт хоёр улсын засгийн газрын хэлэлцээрээр ЗХУ-ын санхүү, материал-техникийн тусламжтайгаар Улаанбаатар хотод 40000 м² ашигтай талбай бүхий орон сууцны барилгыг соёл, үйлчилгээний газруудтай хамт барьж байгуулахаар тохиролцсоны үр дүнд энэхүү хороолол байгуулагджээ. Дээрхи хэлэлцээрийн дагуу

Москва хотын "ГИПРОГОР" институтээс

1-р 40 мянгатын орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөөг зохиож уг төлөвлөгөө ний дагуу 1958-1961 онуудад 3,4 давхар 1093 айл суух олон арван орчин үеийн тохилог байшин барьж ашиглалтанд оруулснаас гадна сургууль, цэцэрлэг, дэлгүүр, гуанз зэрэг соёл үйлчилгээний хэд хэдэн барилга байгууламжийг хамтатган барьж байгуулсан ажээ. Улмаар энэ жишгээр 2-р 40 мянгат баригдсан билээ. Энэ мэтээр 1960-аад оноос хойш одоогийн Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэр дээр төрөл бүрийн зориулалт бүхий олон арван орчин үеийн барилга байшин баригдсан бөгөөд энд жишээ болгон Түүхийн төв музей (өнөөгийн байгалийн түүхийн музей), Лениний музей (одоогийн Чандмань төв), Хувьсгалын музей (одоогийн түүхийн музей), Ард кино театр, Тэнгис кино театр, Худалдаа хөгжлийн банк, Ард банк (одоо Улаанбаатар банк зэрэг газар байрлаж буй нийслэлийн төр захиргааны харьяа байр), Гадаад худалдааны байр, Улсын их дэлгүүр, ХИД-I, "Нарны титэм" худалдаа үйлчилгээний төв зэргийг дурьдаж болно. Тэдгээрийн талаар тус бүрд нь товч тодорхойлон өгүүлж болох боловч энэ удаа тэр болгоныг багтаан бичих зорилго тавьсангүй. Тэрчлэн өнөөгийн Чингэлтэй дүүргийн төв хэсгийн эртний түүхт гудамж, өргөн чөлөө олон байгаа бөгөөд тэдгээрийн зарим нэгнээс энд зөвхөн цухас төдий өгүүлье.

Өнөөгийн Чингэлтэй дүүргийн хил хязгаарыг зааглан Улаанбаатар хотын баруун зүүн жигүүрийг холбон орших хамгийн урт гудамж бол Энхтайвны гудамж билээ. Энэ гудамжны баруун хэсгийн зурвас зай буюу Төв холбооноос баруун 4 зам хүрэх хэсэг Чингэлтэй дүүрэгт харьяалагдах нутгийн зааг хил бөгөөд урьд нь энэ зам Хувьсгалын зам, Сталины гудамж гэх зэргээр нэрлэгдэж байгаад 1960 оноос Энхтайвны гудамж хэмээн нэрлэгджээ.

Хуучин "Октябрийн гудамж" хэмээн олон жил нэрлэгдэж ирсэн бас нэгэн том гудамж одоогийн Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт орших бөгөөд энэ нь нийслэл хотын их түүхт гудамж болно. Энэ гудамж нь ХҮИИ зууны эцсээс XIX зууны дунд үед үүсэн бий болсон, худалдаа зах зээлийн ихээхэн хөл үймээнтэй гол гудамж байлаа. Энэ гудамжны баруун хэсэг Мебелийн үйлдвэрийн зүүн хойт их тойрог замаас Дүрслэх урлагийн музей хүртэл үргэлжлэх хэсгийг урьд нь Худалдааны гудамж, түүнээс зүүн тийш төв талбай хүртэлх хэсгийг Чойбалсангийн чөлөө гэж

нэрлэж байжээ. Хувьсгалаас өмнө Худалдааны гудамжны зүүн эх хавьд "Өндөр хот", түүнийг залгаад "Махан дов" гэж нэршсэн махны худалдааны зах, баруун талд нь барааны зах, түүний хойт талаар хаант Оросын худалдаачдын пүүс дэлгүүрүүд, дунд биеэр нь Хятадын худалдаачдын дэлгүүр, пүүс, гуанз байрладаг байжээ. Мөн энэ гудамжны эргэн тойрон Америк, Герман, Швед, Англи зэрэг бусад орны иргэд худалдаачид аж төрж үйл ажиллагаагаа явуулдаг, өөрөөр хэлбэл нийслэл Хүрээний гадаад зах зээлийн өрсөлдөөний гол талбар нутаг болж байв. Өмнө нь бидний өгүүлсэн түүхэн зарим жишээ баримтууд ч энэхүү гудамжны үүх түүхийг тодорхой хэмжээгээр тодотгон өгч буй болов уу. 1934 оны 8-р сараас эхлэн Хотын захиргааны шийдвэрээр энэхүү гудамжийг тохижуулж, явган хүний болон авто машины зам зассан байна.

Нийслэл хотын шинэчлэн байгуулах эхний төлөвлөгөөгөөр тус гудамжны хойт талаар Туул ресторан, 96 айлын орон сууц, Үйлдвэрлэл хоршоолол, худалдаа үйлчилгээний нэгдсэн барилга, урьд талаар нь 2-р 40 мянгат, сургууль, дэлгүүр, гуанз зэрэг соёл үйлчилгээний шинэ шинэ барилгуудыг ЗХУ-ын техник, эдийн засгийн тусламжтайгаар барьж байгуулжээ. Улаанбаатар хотын АДХГЗ-ны 1970 оны 79-р тогтоолоор уг гудамжийг "Октябрийн гудамж" хэмээн нэрлэх болсон ба одоо энэхүү гудамжийг хуучин уламжлалыг харгалзан "Худалдааны гудамж" хэмээн сэргээн нэрлэж байна.

Чингэлтэй дүүргийн дэвсгэр нутаг дээр дамнан орших бас нэг уламжлал түүхт гудамж бол "Самбуугийн гудамж" юм. Энэ гудамж Гэсэр сүмийн урд уулзвараас Сансар хоршооллын зүүн уулзвар хүрэх бөгөөд 1972 оноос манай нам, төрийн нэрт зүтгэлтэн Ж.Самбуугийн дурсгалд зориулж түүний нэрээр нэрлэх болжээ. Самбуугийн гудамжны баруун хэсэг болох хуучин Найрамдлын "А" гудамжны ихэнх хэсэг үндсэндээ Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт оршино. Энэ гудамжны үүслийг мөшгөн үзвэл, XIX зууны үеэс эхтэй бөгөөд тэр үеэс "Хятадын өргөн чөлөө" гэж нэрлэгдэж байжээ. Энэ өргөн чөлөөнд гол төлөв Хятад худалдаачид, гар урчууд төвлөрөн сууж байснаас гадна үндэсний дотоод зах зээлийн гол төв байрладаг ихээхэн хөл хөдөлгөөнтэй газар байв. 1920 оны эхээр Гамин цэрэг энэ өргөн чөлөөнд үүрлэн Барон Унгернтэй дайтах хаалт бэхлэлтээ байгуулан байрлаж байв.

Дараа нь мөн Барон Унгерн энэ гудамжны нэгэн пүүсийн хашаанд улаан халзтай олон гэр бариулан сууж байсан гэдэг. Нөгөө талаар энэ өргөн чөлөө нь Монголчуудын үндэсний эрх чөлөө тусгаар тогтнолын тэмцэл, үзэл санаа үүсэн бүрэлдэж өрнөн гарч байсан онцлогтой нутаг. Жишээлбэл: 1907, 1908 оны үед одоогийн Их тойруу гудамж болон Худалдааны гудамжны уулзвар орчимд Монгол, Хятад иргэдийн хооронд томоохон зодоон болж байсан гэх ба мөн 1910 оны хавар энэхүү өргөн чөлөөнд орших ДА-Ши-Юа-Юань хэмээх Хятад пүүснийхэн болон Хүрээний олон монгол лам харчуудын хооронд том мөргөлдөөн гарч, улмаар түүнийг зохицуулахаар Манж амбан олон түшмэл цагдаа дагуулан ирэхэд лам хар олон зуун хүн цугларч тэднийг чулуу модоор шидэн хөөж дургүйцэл тэмцлээ илэрхийлж байсан нь түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн байдаг.

Тэрчлэн өргөн чөлөөний зүүн хойт талд орших “Нардом” (“Ардын ордон” гэгдэх энэхүү байрны суурин дээр хожим гадаад худалдааны өндөр барилга баригдсан билээ) хэмээх клуб, түүний өмнө этгээдэд орших Орос хороололд суух орос, буриадын хувьсгалт дэвшилт үзэл бүхий хүмүүс, мөн өмнө өгүүлсэн Чоортын пүүсний хоёр давхар модон байшин тэнд ажиллаж байсан оросын хувьсгалч үзэл санаа бүхий хүмүүс зэрэг нь Монголд үндэсний ардчилсан үзэл санааг дэлгэрэн хөгжих явцад зохих түлхэц үзүүлж байсан юм. 1990 оны ардчилсан хувьсгалын жилүүдэд мөн л энэ орчимд буюу Ялалтын талбайд олон удаагийн жагсаал цуглаан болж, үндэсний эх оронч ардчилсан үзэл санаа цууриатаж байсныг бид мэдэх билээ. 1950-иад оноос энэхүү гудамжны хоёр талаар Үндэсний түүхийн музей, Хувьсгалын музей, Галын газар, Хүүхдийн хувцасны үйлдвэр, Үйлдвэр хоршооллын төв зөвлөл, Оёдлын үйлдвэр, Лениний музей, Гадаад худалдааны яам, ХИД-1-ийн барилга зэрэг томоохон барилгууд баригджээ.

Тэдгээрий дотор түүх соёлын үнэт арвин сан хөмрөг бүхий манай улсын хоёр гол музей томоохон байрыг эзэлнэ. Ард түмний өв соёлыг нандигнан хадгалж, түмэн олондоо дэлгэн үзүүлж байдаг байгууллага болох “Музей” хэмээх тухайлсан байгууллага байгуулах асуудал анх 1922 оны намар сөхөгдөн тавигдаж, эхний дээж үзмэрүүд болох хэдхэн тооны зүйлс цуглуулан эх үүсвэрээ тавьжээ. 1923 оны намар Судар бичгийн хүрээлэнгийн нэр дээр Жамьян гүний хашаанд хуримтлуулан цуглуулаад байсан

дээрх цөөхөн хэрэглэгдэхүүндээ тулгуурлан Судар бичгийн хүрээлэнгийн шийдвэрээр музейг нээсэн байна. Анх музей нээсэн жижиг байшин одоогийн Улаанбаатар зочид буудлын суурин дээр, УБ хотын МАХН-ын хорооны байрны зүүнтээ байжээ. Тийнхүү эх үүсвэрээ тавьж, үйл ажиллагаагаа эхэлсэн музейг Монгол улсад албан ёсоор байгуулах, цаашид өргөжүүлэн хөгжүүлэх тухай тогтоол шийдвэр 1924 онд гарч, тэр цагаас түүх соёл, байгалийн сэдэв чиглэлээр сан хөмрөгөө бүрдүүлэн ажиллаж ирсэн ажгуу. Үндэсний музейг үүсгэн байгуулах, улмаар хөгжүүлэх үйл хэрэгт Онход овогт Жамьян гүнтэй анхнаас нь хамтран ажиллаж, хүчин зүтгэж, гардан хэрэгжүүлсэн гавьяатай нэгэн хүн бол манай ахмад бичгийн хүн, уран гарт Н.Дэндэв гуай байлаа. Түүний хүчин зүтгэлээр музей өөрийн өнгө төрхөө олсон хэмээн хэлж болно. Гэвч манайд музейн зориулалттай барилга байшин ер байсангүй бөгөөд анх 1971 онд л музейн зориулалтаар тусгайлан барьсан шинэ барилга ашиглалтанд орсон нь чухал үйл явдал болсон юм. Энэхүү зориулалтын байранд тухайн үед “Ардын хувьсгалын музей” нээгдэн, 1990-ээд оныг хүртэл ажиллаж байв. 1992 онд тус музейн үзүүлэгийг буулган өөрчлөх, Улсын төв музейгээс түүх, угсаатны зүйн хэрэглэгдэхүүн, сан хөмрөгийг шилжүүлэх үндсэн дээр “Үндэсний түүхийн музей” эмхлэгдэн байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулах болжээ. 1993-1994 оноос эхлэн тус музейд угсаатны зүйн чиглэлээр мал аж ахуй, тоглоом наадгай, хөгжмийн дурсгал: түүхийн чиглэлээр 1921 оны үндэсний хувьсгалын үе, орчин үеийн гадаад харилцааны хэсгийг шинээр байгуулсаны дээр гоёл чимэглэл, хувцасны төрөлжсөн үзүүлгийг эртний үеэс Манжийн үеийг хамруулан хийх арга хэмжээнүүдийг авсан байна. Музей өдгөө 30 гаруй ажиллагсадтай бөгөөд музейн сан хөмрөгт эртний судлал, дундад зууны түүх, орчин үеийн түүх, гэрэл зураг дуу авиа, баримт бичиг, угсаатны зүйн үнэт эдлэл, дээл хувцас, сав суулга, хөгжмийн зэмсэг, гэр орон сууц, ахуйн эд зүйл, ардын урлаг, шашны хэрэглэгдэхүүн гэсэн олон зүйлийн ховор нандин үзмэр хадгалагддаг.

Чингэлтэй дүүрэгт орших түүх соёлын нэг томоохон төв нь одоогийн Байгалийн түүхийн музей юм. Энэ музейн эх суурь нь 1924 онд манайд анх музей байгуулагдахад тавигдсан бөгөөд тэр цагаас хойш олон жилийн турш түүх, угсаатны зүй, байгалийн шинжлэх ухааны чиглэлийг бүхэлд нь хамарсан өргөн цар хүрээг

хамран, Улсын Төв музей нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна. 1992 онд уг музейн бүтцэд өөрчлөлт оруулж, түүх, угсаатны чиглэлийг салган зохион байгуулснаар хуучин байрандаа үлдэн "Байгалийн түүхийн музей" нэрээр дагнан ажиллах болсон билээ. Музей өдгөө нийт 30 гаруй ажилтан, ажиллагсадтай, сан хөмрөг нь байгалийн салбар шинжлэх ухааны ангиллаар геологи, ургамал судлал, хоёр нутагтан, мөлхөгчид, загас, шавьж, шувуу, хөхтөн гэсэн хэсгүүдээс бүрдэх ба тэдгээрийг тус бүрд нь хариуцан ажилладаг эрдэм шинжилгээний ажилтнуудтай юм.

Сүүлийн үед музейн үзүүлэгийг байнга шинэчлэн сайжруулж байгаа бөгөөд шинээр шувуу судлал хөхтний хэсгийг байгуулж нийтэд дэлгэн үзүүлсэн төдийгүй бусад хэсгүүдийг ч шинэчлэн баяжуулсан байна. Эдүгээ Байгалийн түүхийн музей байрлаж буй энэхүү 3 давхар барилга нь анх 1956 онд сургуулийн зориулалтаар баригдсан боловч үндсэндээ музейн чиглэлээр олон жил ашиглагдаж ирсэн ажээ. Дашрамд тэмдэглэхэд уг музейн өмнө, үүд хаалгыг нь сахин хамгаалж орших хоёр чулуун арслан ч өөрийн туулж ирсэн түүхтэй бөгөөд энэ нь анх одоогийн Хүүхдийн урлан бүтээх төвийн өмнүүрхэн байсан Монгол төрийн гал голомтын төв-Богдын шар ордны их хашааны өмнөд үүдний хүндэтгэлийн асартай хаалганы хоёр талд байрладаг байжээ. Хожим тэр хавийн хуучны хашаа байрыг буулгасны дараа уг чулуун арслангуудыг улсын төв музейн үүдэнд байрлуулсан нь энэ болой.

Хуучин Дайчин бэйсийн хорооны нэгэн гудамжны адагт 1920-иод оны үед улсаас тусгайлан өрөмдмөл худаг малтан гаргасан нь олны дунд "Өндөр худаг" хэмээн нэршжээ. Энэхүү худаг нь хотын хөдөлмөрчдийн усны хэрэгцээг хангахад их үүрэг гүйцэтгэж байсан бөгөөд уг худгаас хувийн ба хотын захиргааны морин тэргээр ус зөөврлөгчид үүрээс үдшийн бүрий болтол тасралтгүй цувдаг байсан аж. Өндөр худгаас хойш нь нэвт гарч, Хятадын өргөн чөлөөнд нийлэх нарийн гудамжаар ус зөөврийн морин тэрэг гол төлөв явдаг байсан тул түүхэнд "Усны гудамж" гэж алдаршжээ. Усны гудамж нь зуны цагт борооны болон асгарсан зөөврийн усны улмаас ихээхэн шавар шавхайтай, өвлийн цагт мөсдөж гулгаа халтиргаатай болдог байв. 1957-1960-аад онд ЗХУ-ын тусламжаар 1,2-р 40 мянгатын орон сууцны барилгыг барьж байгуулах явцад хуучин усны гудамжны хашаа байшингууд

буулгагдаж ормон дээр нь шинэ хороолол гудамжууд бий болжээ. Түүний нэг нь Нацагдоржийн гудамж бөгөөд Улсын их дэлгүүрийн зүүн өмнө уулзвар, Энхтайвны гудамжнаас хойш хуучин Октябрийн гудамжийг хөндлөн гарч Найрамдлын (Самбуугийн) гудамжтай нийлэх тэрхүү гудамжийг 1966 оноос Улаанбаатар хотын АДХГЗ-ны тогтоолоор Д.Нацагдоржийн нэрэмжит болгосон ажээ. Энэ нь зохих түүхэн үндэстэй байсан бөгөөд их зохиолч Нацагдорж тус гудамжны зүүн биед байрладаг байсан Оросын хөлсний хэдэн байшингийн нэг болох Соловьевын байшинд гэргий Нинатай ханилж байх үедээ амьдран сууж зохиол бүтээлээ туурвиж байсан ба амьдралынхаа сүүлчийн жилүүдэд амьдран сууж, олон зохиол бүтээлээ туурвисан байшин одоогийн 1-р сургуулийн хойд тал, дээрх гудамжны эхэн хавьд байсан гэдэг. Гэвч 1990-ээд оноос хойш хуучин Сталины гудамжийг Нацагдоржийн нэрээр нэрлэх болж, харин энэ гудамжийг Баруун Сэлбийн гудамж гэдэг болжээ. Нацагдоржийн гудамжийг 1966-1971 онуудад тохижуулан засаж явган хүний зам засаж мод зүлэг тарин гэрэлтүүлсэн ба тэр үеэс уг гудамжны төгсгөлд Оёдлын үйлдвэр, Усны аж ахуйн яам гэх зэрэг олон томоохон барилгууд баригдсан байна.

Ногоон нуурын хойт дэнжид 1950-иад онд Барилгачдын нэгдсэн хорооны нэгэн ижил дан барилгууд барьж түүндээ 1000 айл байрлуулснаар бидний сайн мэдэх "Дэнжийн 1000" хэмээх нэгэн хороолол бий болсны дээр мөн тэр үеэс хотын төв хэсгийн газарт орсон айлуудаар бүрдсэн "Булгийн", "Хайлаастайн" гэх мэт олон гудамж бүхий гэр хорооллууд Чингэлтэй уулын бэлээр бий болох зэргээр он цаг наашлах тутам хүн ам олшрон, дүүрэг өдрөөс өдөрт хаяа тэлэн өргөжиж ирсэн байна.

Эртнээс олон хэлийн хүн амьтан төвлөн нутаглаж, их хотын хөл үймээн, хөгжим цэнгүүн, хөгжил дэвшил, шинэ сэргэг зүйлийн голомт болсоор ирсэн Чингэлтэй дүүргийн энэхүү уламжлал түүхт дэвсгэр нутагт цаашид ч үйл хэрэг энд өрнөж, шинэ шинэ барилга байшин сүндэрлэн босч, түүхийн хуудас нь улам бүр зузаарах нь дамжиггүй.